



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын волейболын тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын волейболын шигшээ тэмцээний урьдчилсан тоглолтыг 2018 оны 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо, "Гүн галуутай" цогцолбор сургууль, "Боловсрол" цогцолбор сургууль, 125 дугаар сургуулийн спорт зааланд, 11 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд "Буянт-Ухаа" спортын ордонд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 3.920.000 /Гурван сая есөн зуун хорин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.


4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД


Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын
VII наадмын волейболын урьдчилсан тоглолт болон
шигшээ тэмцээн зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 9 x 2 x 50.000 төг = 900.000 төг 9 x 2 x 40.000 төг = 720.000 төг 9 x 2 x 30.000 төг = 540.000 төг	2.160.000
2.	Өргөмжлөл:	60.000
3.	Шүүгчдийн ажлын зардал: 10 хүн x 2 өдөр x 50.000 төг = 1.000.000	1.000.000
4.	Тээврийн зардал:	60.000
5.	Медаль: 54 ш x 10.000 = 540.000 төг	540.000
6.	Анонс, цом	100.000
	ДҮН:	3.920.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн
А/А5 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын
VII наадмын волейболын урьдчилсан тоглолт болон
шигшээ тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн

Ерөнхий шүүгч: 1. Б.Отгонбаяр
Шүүгч 2. Н.Солонго
3. Н.Нарантуяа